



**ХЭНТИЙ АЙМГИЙН
НОРОВЛИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 30 өдөр

Дугаар A/85

Жаргалант

**Согтууруулах ундаа худалдах, түүгээр
үйлчлэхийг хориглох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийг 66.1, Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.10, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалт, аймгийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А/321 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдөр сумын хэмжээнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглосугай.

2.Захирамжид дурдсан хугацаанд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхгүй байхыг согтууруулах ундаа худалдан борлуулах үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагуудад үүрэг болгосугай.

3.Сумын нутагт дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагыг мэдээллээр хангаж, захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Цагдаагийн хэсгийн төлөөлөгч (О.Эрдэнэдалай), цагдаа (Б.Анхбаяр) Жаргалант багийн Засаг дарга (Г.Оюунчимэг) нарт даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Шижирмөнх)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.ДАВААЖАРГАЛ